

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
БЭХБАТ ОВОГТОЙ ОЧГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1.Байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг нэгтгэн тайлагнана.							
1.	Салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Санал хүргүүлсэн эсэх	-	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах санал болон байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/542 дугаар тушаалаар байгуулж, нарийн бичгийн даргаар ажилласан. Ажлын хэсгийн хурлыг 12 дугаар сарын 06, 12, 13-ны өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, саналыг эцэслэн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2489 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.	12-01	
2.	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах	Төлөвлөгөө батлуулсан эсэх	-	1	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд тусгах санал ирүүлэх тухай Захиргаа, удирдлагын газрын даргын 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/2418 дугаар албан бичгийг боловсруулан зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлсэн. Ажлын хэсгийн хурлыг 12 дугаар сарын 06, 12, 13-ны өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, ХШҮАХ-ээс ирүүлсэн холбогдох шинжилгээ болон зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн саналыг тус тус хэлэлцэв. Төлөвлөгөөнд 5 зорилгын хүрээнд 18 арга хэмжээ тусгаж, арга хэмжээ тус бүрээр шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхойлсон. Ажлын хэсгийн хурлаар төлөвлөгөөний төслийг хэлэлцэж,	12-06	

1	2	3	4	5	6	7	8
					эцэслэснийг 12 дугаар сарын 13-ны өдөр удирдлагын багт танилцуулж баталгаажуулав. Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг ажлын хэсгийн тушаалын хамт 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2489 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Түүнчлэн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэ маягтын дагуу боловсруулж, нэгжийн даргаар хянуулан ХЗДХЯ-нд 01 дүгээр сарын 03-ны өдөр цахимаар хүргүүлсэн. ХЗДХЯ-ны ТЗУГ-аас 04 дүгээр сарын 03-ны өдөр ирүүлсэн байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг шинэ загвараар боловсруулан хүргүүлэх яаралтай чиглэлийн дагуу дахин боловсруулж, ХЗДХЯ-ны ТЗУГ-т цахимаар хүргүүллээ.		
3.	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах	Төлөвлөгөө батлуулсан эсэх	-	1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлснийг нэгтгэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөний төслийг 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/2600 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, яамнаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгасан. Төлөвлөгөөг хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр хянан баталгаажуулсныг хүлээн авч, ERP системээр нийт албан хаагчдад танилцууллаа. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан 16 зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөөг хүлээн авч, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийлгэн 01 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, нэгж бүрд хүлээлгэн өгөв. Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	12-01	
4.	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Тайлангийн тоо	2	1	Байгууллагын даргын 2024 оны А/455 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын үйл ажиллагааг	06-12	

1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах				төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар"-ын дагуу 06 дугаар 20-ны өдрийн дотор зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авч, 25-ны өдөр ХШҮАХ-т хүргүүлнэ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай танилцуулга, анхаарах асуудлыг тусгасан Захиргаа, удирдлагын газрын даргын 05 дугаар сарын 23-ны өдрийн 02/69 дүгээр дотоод албан бичиг боловсруулж, нийт албан хаагчдад ERP системд нийтэлж танилцууллаа.		
5.	Байгууллагын жилийн эцсийн тайлангийн хурал зохион байгуулах	Хурал зохион байгуулсан эсэх	1	1	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг 12 дугаар сарын 27-ны өдрийн 01-02/63 дугаар удирдамжийн дагуу мөн өдөр зохион байгуулсан. Үр дүнг 12 дугаар сарын 31-ний өдрийн 01-02/159 дүгээр илтгэх хуудсаар удирдлагад танилцууллаа. Байгууллагын даргын тайлангийн хурлыг нээж хэлэх үгийг боловсруулж, 2024 оны онцлох үйл ажиллагааны видео танилцуулгыг олон нийттэй харилцах ахлах мэргэжилтний хамт хийж гүйцэтгэн тайлангийн хуралд нийт албан хаагчдад танилцуулсан болно.	12-12	
Зорилт 2.Байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг нэгтгэн тайлагнана.							
6.	Байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн төлөвлөгөө батлуулах	Батлуулсан төлөвлөгөөний тоо	12	6	Байгууллагын даргын А/455 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар"-ын дагуу байгууллагын үйл ажиллагааны 01-06 дугаар сарын төлөвлөгөөнд тусгах саналуудыг зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн боловсруулан удирдлагаар батлуулж, тухай бүр Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ээр албан хаагчдад мэдээлж ажиллалаа.	01-12	
7.	Байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах	Нэгтгэсэн тайлангийн тоо	12	6	Байгууллагын үйл ажиллагааны 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-05 дугаар сарын төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн тайлан боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст "Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах	01-12	

1	2	3	4	5	6	7	8
					заавар"-т заасан хугацаанд тухай бүр хүргүүлж, үнэлгээ хийлгэн ажиллалаа. Гүйцэтгэл 93.9, 95.1, 92.2, 95.1, 86.1, 97.7 хувьтай тус тус дүгнэгдсэн.		
Зорилт 3.Байгууллагын албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлт болон байгууллагын даргын баталсан тушаалын хэрэгжилтийн мэдээ, тайлан хянана.							
8.	Бичиг хэргийн эргэлтийн хагас жил, жилийн эцсийн тайлан, 7 хоног тутмын мэдээ хянах	Хянасан тайлан, мэдээний тоо	54	27	Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", 2021 оны А/119 дүгээр тушаалаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын дагуу байгууллагын бичиг хэргийн эргэлтийн 2024 оны жилийн эцсийн нэгдсэн тайланг хянасан. Мөн албан бичиг шийдвэрлэлтийн 27 удаагийн 7 хоног тутмын мэдээг хянасан.	01-12	
9	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн захиргааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангах	Хяналт шалгалтын тоо	3	2	Байгууллагын даргын 01-02/58 дугаар удирдамжийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 06-ны өдрүүдэд Хойд бүс дэх газрын захиргаа, санхүүгийн 2024 оны 01-03 дугаар улирлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийсэн. Тус хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, архив, албан хэрэг хөтлөлтийн цахим системийн ашиглалтыг эрчимжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллагын даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Ажлын хариуцлагыг сайжруулах тухай" 03 дугаар албан даалгавраар үүрэг, чиглэл өгсөн. Албан даалгаврын биелэлтийг холбогдох баримт бичгийн хамт тогтоосон хугацаанд цахимаар хүлээн авч, шаардлагатай баримт бичгийг нэмэлтээр татан хэрэгжилтэд үнэлгээ хийж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01-02/33 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Захиргааны үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 84 хувьтай дүгнэгдлээ.	01-12	

1	2	3	4	5	6	7	8
10.	Байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан хянах	Хянасан тайлангийн тоо	16	8	Байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2024 оны 12 дугаар сар, жилийн эцсийн нэгдсэн тайлан болон 2025 оны 01-05 дугаар сар, нэгдүгээр улирал, хагас жилийн тайланг хянаж, засварлан өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.	01-12	
11.	Байгууллагын даргын баталсан тушаалын хэрэгжилтийн тайлан хянах	Хянасан тайлангийн тоо	1	1	Байгууллагын даргын 2024 онд баталсан тушаалын жилийн эцсийн биелэлтийн тайлан (хүснэгтээр 322 хуудас)-г хянаж засварлан тушаалын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэнд 04 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлэв.	01-06	
Зорилт 4.Байгууллагын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.							
12.	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд түгээх	Түгээлтийн хувь	-	-	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой 93 мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээн дэх өөрийн 2 хаягаар олон нийтэд түгээж ажиллав.	01-12	
13.	Байгууллагын худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үнэлгээний хороонд ажиллах	Үнэлгээний хороонд ажилласан тоо	3	4	Тайлант хугацаанд байгууллагын дараах 4 үнэлгээний хороонд даргаар болон гишүүнээр ажиллаж, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер нээх, баримт бичгийг үнэлэх, хурал зохион байгуулах, хуралд оролцох, захиалагчид хүргүүлэх зөвлөмж боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн оролцоог хангаж ажиллав. Үүнд: 1. Байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/567 дугаар тушаалаар байгуулсан хилийн боомтод виз олгоход шаардагдах тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо (5 багц) 2. Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулсан багаж техник хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо	01-06	

1	2	3	4	5	6	7	8
					3. Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулсан улсын мэдээллийн маягт бэлтгэн нийлүүлэх үнэлгээний хороо 4. Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А/25 дүгээр тушаалаар байгуулсан “Тээвэр шатахуун бэлтгэн нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Мөн Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/359, 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/425 дугаар тушаалын дагуу Хавирга, Цагааннуур, Булган боомтын барилгын хяналт гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж, холбогдох үнэлгээний хуралд оролцов.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал хүргүүлэх	-	-	-	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулга, албан бичгийг хилийн боомт, орон нутаг хариуцсан ахлах мэргэжилтний хамт боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	01-01	
2.	Бодлогын судалгааны зөвлөл байгуулах бэлтгэл ажлыг хангах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	-	-	-	Бодлогын судалгааны зөвлөл байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Зөвлөлийн ажлын албанд ажиллах судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий нэгж, албан хаагчийн талаар танилцуулга боловсруулан удирдлагад 01 дүгээр сарын 07-ны өдөр танилцуулсан. 2. Зөвлөлд гишүүнээр нэр дэвшүүлэх судлаач, эрдэмтний судалгаа хийж, 1 судлаачийн англи хэл дээрх CV-г монгол хэл рүү орчуулан	12-05	

					танилцуулга бэлтгэж ХШҮАХ-ийн даргад илгээв. 3. Зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын талаар ЗУГ-ын дарга, МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн профессор Ж.Баттогтохтой 01 дүгээр сарын 17-ны өдөр хийсэн уулзалтад оролцов. 4. Зөвлөлийн ажиллах журмын төсөлд санал боловсруулж, нэгжийн даргад танилцуулан ХШҮАХ-т 02 дугаар сарын 07-ны өдрийн 02/15 дугаар дотоод албан бичгээр хүргүүлэв. Байгууллагын даргын 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/173 дугаар тушаалаар байгуулсан Монгол Улс дахь "Гадаадын иргэний эрх зүйн байдал, тулгамдсан асуудал, шийдэл" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, холбогдох илтгэл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр ажилласан. Хурлын хөтөлбөр, ажлын төлөвлөгөө, холбогдох албан бичгүүдийг боловсруулах, хянах болон Стратеги судлалын хүрээлэнгээс ХЗДХЯ, ЦХХАЯ, ХХЕГ, ГИХГ-т хүргүүлэх албан бичгийг монгол бичигт хөрвүүлэх ажлыг тус тус хийж гүйцэтгэв. "Гадаад иргэдийн хяналт, бүртгэлийн тогтолцоог сайжруулахад баримталж буй бодлого, үйл ажиллагаа", "Монгол Улс дахь гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал", "Гадаад иргэдийн асуудлаар улс орнуудын баримталж буй бодлого, туршлага сургамж" сэдэвт илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл боловсруулах, эмхэтгэл гаргахад оролцож, бэлтгэл ажлыг ханган эрдэм шинжилгээний хурлыг 04 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа.		
3.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах	-	-	-	Байгууллагын даргын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/357 дугаар тушаалаар байгуулсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 02 дугаар сарын 10, 13, 14, 17-ны өдрүүдэд 4 удаа зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийн хамт хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Энэ хүрээнд Google doc файл	02-03	

					үүсгэж, нэмэлт, өөрчлөлтийн саналыг ажлын хэсгийн гишүүдээс авсан. Мөн 02 дугаар сарын 27-ны өдрийн 02/22 дугаар дотоод албан бичгээр зохион байгууллалтын нэгжүүдээс хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авав. ГИЭЗБТХ-ийн шинэчилсэн найруулгад зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн санал болон бусад холбогдох баримт бичгүүдийг хуулийн мэргэжилтэн А.Энх-Амгаланд 03 дугаар сарын 11-ний өдөр хүлээлгэн өглөө.		
4.	Чиглүүлэх сургалтад хариуцсан ажлын чиглэлээр хичээл заах	-	-	-	Байгууллагын даргын 03 дугаар сарын 20-ны өдрийн 01-02/16 дугаар удирдамжаар шинээр томилогдсон албан хаагчдад “Байгууллагын стратеги төлөвлөлт, тайлан төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал” болон “Боомтын сэргэлт, хилийн боомтуудын тухай” сэдвээр хичээл заав.	03-03	
5.	Холбогдох танилцуулга, албан тушаалтны хэлэх үг бичих	-	-	-	1. Байгууллагын даргын 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар зохион байгуулсан удирдах ажилтны нэгдсэн уулзалт, зөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын хэлэх үгийг боловсруулав. 2. Цахим виз, гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцооны танилцуулгыг тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, ХЗДХСайд, ГХЯ-ны төрийн нарийн бичгийн даргад 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/541, 01/543 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ. 3. Байгууллагын даргын 03 дугаар сарын 28-ны өдөр ГБХНХЯ, ХХҮЕГ-тай хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахад тулгамдаж буй асуудлаар хийсэн хамтарсан уулзалтад оролцож, олон нийттэй харилцах ахлах мэргэжилтний хамт мэдээ бичиж, нийтлэв. 4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнтэй 04 дүгээр сарын 30-ны өдөр хамтран зохион байгуулсан Монгол Улс дахь “Гадаадын иргэний эрх зүйн байдал, тулгамдсан асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын мэндчилгээний үг, байгууллагын даргын нээлтийн үг, Ерөнхийлөгчийн тамгын газрын Хууль зүйн бодлогын газрын даргын хэлэх үгийг тус тус	01-06	

					боловсруулсан. 5. Байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй эрсдэлийн талаар танилцуулга болон зөвлөмжийн төсөл боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд 05 дугаар сарын 21-ний өдрийн н/16 дугаар албан бичгээр хүргүүлээ. 6. Байгууллагын баруун талд байрлалтай шороон талбайг байгууллагын эзэмшилд авах хэрэгцээ, шаардлагын талаар танилцуулга бичиж, 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1107 дугаар албан бичгээр нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1.	Удирдлагын академийн "Монгол бичиг" цахим сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	-	1	Удирдлагын академийн үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдаж сорил өгч тэнцэн сертификат авав. Сертификатын огноо, дугаар: 2025.06, 728502	01-06	
2.	Удирдлагын академийн "Авлигаас ангид төрийн алба" цахим сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	-	1	Удирдлагын академийн "Авлигаас ангид төрийн алба" цахим сургалт хичээлийн хөтөлбөрөөс хасагдсан тул "Тоон гарын үсэг", "Microsoft 365 программын хэрэглээ" цахим сургалтад хамрагдаж, сертификат авав. Сертификатын огноо: 2025.06	01-06	
3.	Жендэрийн үндэсний хорооны удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	-	-	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	07-12	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ОЧГЭРЭЛ

2025 оны 06 дугаар сарын 09